



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Түлэгдлийн эмгэгийг эмчлэх эмнэлгийг
нүүлгэн шилжүүлэх, тусламж үйлчилгээг зохицуулах тухай

Төрийн өмчийн хорооны 2011 оны 358 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ:**

1. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн харъяа Түлэгдлийн эмгэгийг эмчлэх эмнэлгийн барилгыг акталж шинээр цогцолбор барих болсонтой холбогдуулан тус эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнууд, эмчлүүлэгсэд, багаж тоног төхөөрөмжийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн байранд нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж 2012 оны 5 дугаар сард багтаан зохион байгуулахыг Гэмтэл согог судлалын үндэсний төв (С.Отгонгэрэл), түлэгдлийн эмгэгийг эмчлэх эмнэлгийг нүүлгэн шилжүүлэхэд шаардлагатай зардлыг шийдвэрлэхийг яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Отгонбаатар) –т тус тус даалгасугай.
2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогооны төв, тусгай мэргэжлийн төвд үзүүлэх түлэгдэлтийн эмгэгийн тусламж үйлчилгээг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. Орон нутгийн түвшинд түлэгдлийн эмгэгийн оношлогоо, эмчилгээг удирдамжийн дагуу зохион байгуулах, гэмтэл, түлэгдэл, хөлдөлтийн үед төрөлжсөн мэргэжлийн тусламж шаардлагатай тохиолдолд Гэмтэл согог судлалын үндэсний төвд эмчлүүлэгсдийг илгээн эмчлүүлэхийг аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн)-т даалгасугай.

САЙД



Н.ХҮРЭЛБААТАР

ТҮЛЭГДСЭН ӨВЧТӨНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

НЭГ. ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, СУМ ДУНДЫН ЭМНЭЛЭГ

❖ Үзүүлэх тусламж үйлчилгээ:

1. Түлэгдэж гэмтсэн бүсээс холдуулах /гал, цахилгаан, хүчил шүлт, гм/, шатаж буй хувцасыг унтраах, аюулгүй газар гаргах, цаг агаарын таагүй нөхцлөөс хамгаалах.
2. Түлэгдсэн мөчдийн хүйтэн усанд дүрж хөргөх.
3. Түлэгдсэн хэсэгт цэвэр, хуурай боолт, ороолт хийх
4. Мөчийг хөргөсний дараа биемахбодийг даарч, хөрөхөөс сэргийлэх
5. Ам цангахаас сэргийлж бүлээн шингэн / хоросол, цай г.м/ уулгах
6. Өвдөлт намдаах, зүрх судас дэмжих тариаг эмчийн заалтаар хийнэ. Гэрийн нөхцөлд өвдөлт намдаах эм уулгана.
7. Хэрэв өвчтөн шокоор хүндэрсэн бол эмнэлэгт хүргэх явцад эмийн шингэн сэлбэх эмчилгээг хийнэ.
8. Зонхилон тохиолдох оношлогоо, эмчилгээний удирдамжийн дагуу түлэгдэлтийн тусламж, үйлчилгээг үзүүлэх
9. Түлэгдлийн талбай, зэргийг тогтоох
10. Гэмтлийн анхдагч, хоёрдогч үнэлгээ хийх
11. Түлэгдэлтийн шокийг оношлох
12. Амьсгалын зам түлэгдсэн эсэхийг тодорхойлох
13. Хавсарсан гэмтлийг тодорхойлох
14. Яаралтай тусламж үзүүлэх, боолт хийх
15. Гэмтэхээс сэргийлэх, нэмэлт хөнөөлөөс сэргийлэх
16. Дараагийн шатны эмнэлэгүүдтэй холбоо тогтоон оношлогоо эмчилгээний арга зүйн зөвөлгөө авах
17. Хөнгөн болон өнгөц түлэгдэлтэй өвчтөнийг эмчлэх
18. Шаардлагатай тохиолдолд өвчтөний иргэний үнэмлэх, НДД, ЭМД, өвчний тухай болон үзүүлсэн тусламжний талаар мэдээлэл, 13А маягыг бүрдүүлж аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс засал/ гэмтлийн тасаг, мөн Гэмтэл согог судлалын үндэсний төвд шилжүүлнэ.

❖ Түлэгдэлтийн байдал, хэлбэр

Түлэнхийн өвчтөний хүнд, хөнгөн, шокийн зэрэг, эмчилгээ, өвчний тавиланг Франкийн индексээр тодорхойлно.

Энэ нь түлэгдсэн бүх талбайг өнгөц түлэгдэлтийн хувьд шилжүүлсэн нийлбэрээр илэрхийлэгдэнэ. Ингэхдээ гүн түлэгдэлтийн 1% нь өнгөц түлэгдэлтийн 3%-тай тэнцэнэ гэж тооцно.

$$\text{Жишээ нь: } \text{ИФ} = (30 - 15) + (15 \times 3) = 15 + 45 = 60$$

30 – нийт талбай

15 – гүн түлэгдсэн талбай

Хэрэв амьсгалын зам түлэгдсэн бол хүнд хөнгөнийг харгалзан ИФ = 15 – 30 гэж нэмнэ. Хөнгөн шокийн үед түлэнхийн талбай 10 - 15%: ИФ < 30

Дунд зэргийн шокийн үед түлэнхийн талбай 20%; ИФ = 30 – 70

Хүнд шокийн үед түдэнхийн талбай 50% түүнээс дээш: ИФ > 130-аас илүү

ИФ-аар өвчний тавиланг үнэлэхдээ:

Талбай 10-40%, ИФ 30-100 найдвартай; харин нас < 15; > 45 бол эргэлзээтэй

Талбай 40-50%, ИФ 100-120 (15-45 нас) – эргэлзээтэй; нас < 15; > 45 бол найдвар муу

Талбай 50-75% ИФ 120-150 бол тавилан муу буюу найдваргүй гэж үзнэ.

Түлэнхийг түүний хүнд хөнгөнөөс хамааруулан хаана эмчлэх талаар баримтлах чиглэл

Түлэгдэлийн байдал	Зэрэглэл	Хаана эмчлэх
Хөнгөн түлэгдэлт	<ul style="list-style-type: none">Насанд хүрэгсэд II зэрэг түлэгдэлт бүх биеийн гадаргуу (ББГ) 15%-иас бага болНастан, хүүхэд II зэрэг 5%-иас бага болIII зэрэг 2%-иас бага бол	Амбулаториор
Дунд зэргийн түлэгдэл	<ul style="list-style-type: none">Насанд хүрэгсэд II зэрэг 15-25% болНастан, хүүхэд II зэрэг 10-20% болIII зэрэг 10%-иас бага бол	Нэгдсэн эмнэлгийн мэс заслын ба гэмтлийн тасаг
Хүнд түлэгдэл	<ul style="list-style-type: none">Насанд хүрэгсэд II зэрэг 25%-иас их болНастан, хүүхэд II зэрэг 20%-иас их болIII зэрэг 10%-иас их болНүүр, сарвуу, нүд, чих, тавхай, хярзан,Амьсгалын замын түлэгдэлЦахилгааны түлэгдэл	ГССҮТөв

❖ Үзлэг, шинжилгээ

- 1) Түлэгдлийн талбай, гүнийг тогтоох
- 2) Артерийн даралт хэмжих
- 3) Судасны лугшилт тоолох
- 4) Амьсгалыг тоолох

- 5) Түлэнхийтэй өвчтөний хүнд, хөнгөнийг Франкийн индексээр тогтоох
- 6) Хавсарсан гэмтэл байгаа эсэхийг тодорхойлох
- 7) захын судасны хүчилтөрөгчийн хангамжийг тодорхойлох
- 8) Хүзүү, цээж, мөчдийн эргэн тойрон түлэгдэж, тэр нь судас мэдрэлийг дарсан эсэхийг тогтоох
- 9) Цус ерөнхий шинжилгээ
- 10) Шээсний ерөнхий шинжилгээ
- 11) Биохимийн шинжилгээ /эмчийн заалтаар/

❖ Тээвэрлэлт

Хөнгөн болон дунд зэргийн түлэгдэлттэй өвчтөнд шингэн уулгах, өвдөлт намдаах эм өгөөд тээвэрлэнэ.

Хүнд, маш хүнд зэргийн түлэгдэлттэй өвчтөнд тээвэрлэхийн өмнө, тээвэрлэх явцад зүрх судас, өвдөлт намдаах эм бэлдмэл болон шингэн сэлбэх эмчилгээг хийж эмчийн хяналтан дор тээвэрлэнэ.

❖ Эмчийн мэдлэг, ур чадвар

1. Мэдлэг

- Өнгөц ба гүн түлэгдэлтийн шинжүүд
- Түлэгдэлтийн талбай тодорхойлох аргууд /алганы дүрэм, 9-тийн систем/
- Түлэгдэлтийн шокийн зэрэглэл
- Түлэнхийн эмчилгээний зарчим
- Тээвэрлэлт
- Франкийн индексээр өвчний хүнд хөнгөнийг тодорхойлох
- Татрангийн эсрэг ийлдэс эмчилгээ

2. Чадвар

- Түлэнхийд анхны тусламж үзүүлж, цэгцэлгээ, боолт хийх
- Амьсгал, зүрх зогсоход сэхээн амилуулах суурь тусламж үзүүлэх
- Гадуур цус алдалтыг тогтоох
- Сум дундын эмнэлэгт шаардлагатай тохиолдолд венесекци хийх, төвийн венид гуурс тавих
- Давсганд гуурс тавих
- Хүзүү, бие, мөч зузаан түлэгдсэн бол цус шүүртэл зүслэг хийх

ХОЁР. НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, БҮСИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ

- **Үзүүлэх тусламж үйлчилгээ:**
 - 1) Түлэгдэлийн талбай, гүний хэмжээ, амьсгалын замын түлэгдлийг нарийвчлан тогтоох
 - 2) Түлэгдэлийн Франкийн индексийг тодорхойлох

- 3) Түлэнхийн шокийн зэргийг тогтоож, шокоос гаргах эмчилгээ хийх.
- 4) Амьсгалын замын түлэгдлийг эмчлэх, уушигны хаван, хатгаанаас сэргийлэх
- 5) Шаардлагатай тохиолдолд Гэмтэл согог судлалыг үндэсний төвд дуудлага өгөх, зөвөлгөө авах, эмчилгээний тактик боловсруулах.
- 6) Хавсарсан гэмтэлд нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх
- 7) Түлэнхийн хэсгийн эмчилгээг хийх
- 8) Түлэнхийн өвчний хүндрэл, шархны хоёрдогч бохирдол, ходоод гэдэсний зам, бөөр, элэгний хүндрэлээс сэргийлэх, эмчлэх
- 9) Үе мөчний түлэнхийтэй бол үений контрактур үүсэхээс сэргийлэх
- 10) Түлэнхийн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх
- 11) Өвчтөн шокоор хүндэрсэн бол сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний (шокийг эмчлэх) тасагт эмчлэх
- 12) Шаардлагатай тохиолдолд тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэг /ГССҮТ/ -д шилжүүлнэ.
- 13) Түлэгдсэний дараахи 3-5 хоногт дараахи эмчилгээнүүдийг хийнэ.
Шокын эсрэг эмчилгээ:
 - 13.1 Нэгдүгээр шатны эмчилгээний хүрээг нэмэгдүүлнэ.
 - 13.2 Эмчилгээг яаралтай эхлүүлэн тасралтгүй үргэлжлүүлнэ.
 - 13.3 Өвдөлтийн эсрэг эмчилгээ, судасны нэвчих чанар алдагдахын эсрэг, микроциркуляци алдагдахын эсрэг, гиперкоагуляцийн эсрэг, усгүйдэхийн эсрэг, ус эрдэсийн тэнцвэр алдагдалтын эсрэг, хүчил, шүлтийн тэнцвэр, зүрх, судасны систем, амьсгал, шээс ялгаруулах, ходоод, гэдэсний замын үйл ажиллагааны хямралын эсрэг эмчилгээг цогцоор нь хийнэ. Мөн дааруулахгүй байхыг анхаарна.
- 14) Түлэнхийн хүнд хэлбэрийн үед шархыг угаах, зүслэг хийх, боолт солих зэргээр оролдох хэрэггүй. Учир нь энэ нь шокийг гүнзгийрүүлнэ.
- 15) Хүзүү, их бие, мөчний эргэн тойронд зузаан үхжил үүсч, амьсгал, цусан хангамжийг алдагдуулахаар бол некротоми хийнэ.
- 16) Хавсарсан гэмтэлтэй бол гэмтлийн болон мэс заслын нарийн мэргэжлийн тусламж үзүүлнэ.
- 17) Хүнд хэлбэрийн түлэгдэлттэй өвчтөн ялангуяа хүүхдэд боолтыг ерөнхий мэдээгүйжүүлэгтэй хийнэ.
- 18) Шаардлагатай тохиолдолд өвчтөний иргэний үнэмлэх, НДД, ЭМД, өвчний тухай болон үзүүлсэн тусламжний талаар мэдээлэл, 13А маягтыг бүрдүүлж Гэмтэл согог судлалын үндэсний төвд шилжүүлнэ. Тээвэрлэлтийг шокоос гарч, биеийн байдал тогтворжсон үед эмнэлгийн удирдлагын зөвшөөрлөөр шилжүүлнэ.

❖ **Үзлэг. шинжилгээ:**

- 1) Цусны даралт хэмжих
- 2) Судасны лугшилт тоолох
- 3) Амьсгалыг тоолох
- 4) Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- 5) Биохимийн шинжилгээ

- 6) Шээсний шинжилгээ
7) Хоногийн болон цагийн шээс хэмжих,
8) судсаар хийж байгаа болон уух шингэнийг тооцоолох,
9) Зүрхний цахилгаан бичлэг хийх
10) Цээжний рентген зураг авах, харах

Түлэнхийн шок, хурц хордлогоос гарах хүртэл өвчтөнд шаардлагатай шинжилгээнүүдийг өнжөөд давтан хийнэ.

❖ Тээвэрлэлт

Эмнэлгийн зориулалттай тусгай тоноглогдсон тээврийн хэрэгсэл / автомашин, нисдэг тэрэг, онгоц / -ээр Гэмтэл согог судлалын үндэсний төв /түлэнхийн төв/ рүү тээвэрлэнэ

❖ Эм, багаж хэрэгслийн хангалт

1. Сийвэн орлох шингэн
2. Цус, сийвэн, альбумин
3. Шокын эсрэг хийгдэх эрчимт эмчилгээнд шаардлагатай эмийн бэлдмэлүүд болон шингэнүүд антикоагулянт, антиагрегант,
4. ангиопротектрууд, мембранпротектор,
5. антигипоксанта
6. спазмолитик
7. диуретик
8. гемокорректор
9. ингибитор протеаз
10. гормон
11. Төвийн болон захын венийн гуурс, трахеостомын иж бүрдэл
12. Төрөл бүрийн чигнүүд
13. шархыг цэвэрлэж боох эм, уусмал
14. ариун боолт

❖ Мэргэжлийн эмчийн мэдлэг, ур чадвар

А. Мэдлэг:

- Өнгөц ба гүн түлэгдэлтийн шинжүүд
- Түлэгдэлтийн талбай тодорхойлох аргууд /алганы дүрэм, 9-тийн систем/
- Түлэгдэлтийн шокийн зэрэглэл
- Түлэнхийн эмчилгээний зарчим
- Тээвэрлэлт
- Франкийн индексээр өвчний хүнд хөнгөнийг тодорхойлох
- Татрангийн эсрэг ийлдэс эмчилгээ

В. Ур чадвар:

- Түлэнхийд анхны тусламж үзүүлж, цэгцэлгээ, боолт хийх

- Амьсгал, зүрх зогсоход сэхээн амилуулах суурь тусламж үзүүлэх
- Гадуур болон дотуур цус алдалтыг тогтоох
- Венесекци хийх, төвийн венид гуурс тавих
- Давсганд гуурс тавих /4 гуурсны арга /
- Хүзүү, бие мөчдөд зузаан түлэгдсэн бол цус шүүртэл зүслэг хийх
- Некрозтоми
- Бага хэмжээний арьс нөхөх
- Түлэнхийн хэсэг газрын эмчилгээний технологийг эзэмшсэн байх

ГУРАВ. ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

❖ Үзүүлэх тусламж үйлчилгээ:

- 1.Түлэгдсэн өвчтөнд гэмтэл согогийн мэргэжлийн эмчийн тусламжийг бүрэн хэмжээгээр үзүүлэх
- 2.Зөвлөх эмчилгээний тусламжийг аймаг бүсийн хэмжээнд үзүүлэх.
- 3.Боловсон хүчинг сурган дадлагажуулах.
- 4.Өвчтөнийг хяналтанд авах
- 5.Түлэнхийн дараах сорив татанхай арилгах мэс заслын эмчилгээ хийх
- 6.Түлэгдлийн өвчлөл, нас баралт, хүндрэл, түлэгдлийн эмчилгээний хугацаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийн талаар мэдээ, тайлан гаргах
- 7.Судалгааны ажил хийх
- 8.Осол гэмтлээс сэргийлэх

❖ Өвчний байдал, шинж

Хүнд, хөнгөнийг Франкийн индексээр тогтоож эмийн болон мэс заслын эмчилгээг хийнэ.

❖ Үзлэг, шинжилгээ

Дараахи шинжилгээнүүдийг хийнэ. Үүнд:

- ❖ цусны дэлгэрэнгүй, биохими, шээс, рентген, ЭХО оношлогоо, зүрхний цахилгаан бичлэг, хүчил шүлтийн тэнцвэр, коагулограм, мөн эмчийн заалтаар хийгдэх бусад шинжилгээнүүд
- ❖ Тоног төхөөрөмжийн хангалт
 - Төрөлжсөн мэргэжлийн төвийн стандартын дагуу багаж, тоног төхөөрөмж, эм, хэрэгсэл хангалттай байх
- ❖ Төрөлжсөн мэргэжлийн эмчийн мэдлэг, ур чадвар

А. Мэдлэг:

 - Өнгөц ба гүн түлэгдэлтийн шинжүүд
 - Түлэгдэлтийн талбай тодорхойлох аргууд /алганы дүрэм, 9-тийн систем/
 - Түлэгдэлтийн шокийн зэрэглэл
 - Түлэнхийн эмчилгээний зарчим
 - Тээвэрлэлт
 - Франкийн индексээр өвчний хүнд хөнгөнийг тодорхойлох

- Татрангийн эсрэг ийлдэс эмчилгээ

Б. Ур чадвар:

- Түлэнхийд анхны тусламж үзүүлж, цэгцэлгээ, боолт хийх
- Амьсгал, зүрх зогсоход анхны сэхээн амилуулах суурь тусламж үзүүлэх
- Гадуур болон дотуур цус алдалтыг тогтоох
- Венесекци хийх, төвийн венид гуурс тавих
- Давсганд гуурс тавих /4 гуурсны арга /
- Хүзүү, бие мөчдөд зузаан түлэгдсэн бол цус шүүртэл зүслэг хийх
- Түлэнхий өвчний үед үзүүлэх эмгэг жамын эмчилгээ хийх
- Некрозектоми
- Түлэнхийн хэсэг газрын эмчилгээний технологийг эзэмшсэн байх
- Том хэмжээний арьс нөхөх
- Нөхөн сэргээх мэс засал
- Соривны пластик мэс засал

ooooOoooo